

ЦАХИМ АРДЧИЛАЛЫН АСУУДАЛД

Д.БУМДАРЬ

Доктор, озо проф, МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс Төр Судлалын Тэнхим

Б.ДӨЛГӨӨН
Магистрант

Түлхүүр үг: цахим ардчилал, ICT, electronic democracy

Abstract: Electronic democracy is an important theme which social informatics must research next to electronic capitalism. The purpose of this paper is, along with this line, to address research tasks on decision, deliberation and information in electronic democracy from a decision scientific standpoint.

Цахим ардчилал нь /electronic democracy, e-democracy/ нийгэм дижиталчлагдаж байгаа өнөө үед чухал асуудал болж байна. Үүнтэй ижил утга бүхий teledemocracy, digital democracy, cyber democracy, virtual democracy зэрэг хэллэг, ойлголтууд байдаг. Ер нь бол цахим ардчилал хэмээх нь улс төрийн шинжлэх ухааны судалгааны шинэ сэдэв, шинэ чиглэл болж байгаа юм.

Цахим ардчилалын хамрах хүрээ:

- шийдвэр гаргалт
- хэлэлцүүлэг явуулах
- мэдээлэл гэсэн үндсэн гурван хүрээг хамардаг.

Цахим ардчилал хэмээх ойлголтыг эрдэмтэд янз янзаар тодорхойлсон байдаг. Аливаа улс төрийн үйл ажиллагааг явуулж ирсэн удамжлалт аналогн систем дээр нэмээд, ICT /Information and Communications Technology/ болон СМС /Computer Mediated Communication / ашиглан цаг хугацаа, орон зай болон бодит саад бэрхшээл, хязгаарлалтуудыг үл харгалзан, ардчилсан засаглалыг хэрэгжүүлэхийг цахим ардчилал гэнэ¹.

Мэдээлэл түгээх, сонгууль явуулах, санал хураах, хэлэлцүүлэг өрнүүлэх явцад улс төрчид болон иргэдийг холбохын тулд цахим технологийг ашиглаж байгаа явдлыг цахим ардчилал гэнэ².

Эдгээр тодорхойлолтууд нь ерөнхий тоочиж тайлбарласан шинжтэй бөгөөд цахим ардчилал хэмээх ойлголтыг нэг мөр товч тодорхой илэрхийлж тэр бүр чадахгүй байгаа нь харагдаж байна. Үгийн явцуу утгаар нь илэрхий ICT бол хэрэгсэл (instrument) юм. Энэ нь онлайн системийг ашиглан санал хураах, хэлэлцүүлэг өрнүүлэх, үйл ажиллагаа, мэдээллийг иргэд бүлэгт компьютерийн тусламжтайгаар түргэн шуурхай, хүргээмжтэй, илүү үр дүнтэй хүргэх явдал гэж хэлж болох юм.

Харин үгийн өргөн утгаар илэрхийлбэл, ICT нь хэрэгслээс хавьгүй илүү баялаг агуулгатай юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, цахим ардчилал (e-democracy)-ыг ойлгохын тулд эхлээд ардчилал, ардчиллын үндсэн системийг бүхэл бүтэн байдлаар нь ойлгож мэдээний дараа ардчиллын тэрхүү үндсэн системдээ цахим ардчиллын олон талт бодит байдал, судалгаа, дүгнэлтийг цогц байдлаар нь багтаан авч үзэх явдал юм.

Үүний тулд улс төрийн тогтолцоо, засаглал, иргэний нийгэм хэмээх үндсэн гурван бүрэлдэхүүн хэсгийг, тэдгээрийн хоорондын хамаарал, нөлөөллийг сайтар таньж мэдэх шаардлагатай байдаг.

Ардчиллын онол нь цахим ардчиллын онол-арга зүйн ерөнхий суурь нь болж байдаг. Ардчиллын онол, загварууд нийнхүү олон янз байдаг учир илүү ойлгомжтой нээн харуулахын тулд эрдэмтэн судлаачид түгээмэл шинжээр нь ангилах оролдлого хийж ирсэн байдаг. Судлаач Астром (Karl J. Astrom) дараах байдлаар ангилж үзсэн байдаг. /Хүснэгт .1/

/Хүснэгт .1/

	Загварууд		
	Quick democracy	Strong democracy	Thin democracy
Зорилго	Иргэдэд эрх мэдлийг шилжүүлэх	Зөвшилцөл	Үр дүн сонголт
Легитим чанар хууль ёсны	Шийдвэрийг олонхийн саналаар гаргадаг	Нийтээр хэлэлцүүлж шийдэх	Тайлагтах, хариуцлага

¹ Hacker, K.L and van Dijk, K (eds) 2000. *Digital Democracy: Issues of Theory and Practice* SALE, London.

² Gronlund, A. 2001 Democracy and IT- Framed Society *COMMUNICATION OF THE ACM*, p.26

Иргэдийн оролцоо	Сайн дурын үндсэн дээр оролцох, шийдвэр гаргах	Санал гаргаж оролцох	Хэрэглэгчийн байр суурь
Эрх баригчдын эрх, үүргийн зааг	Эрх, үүргийн хязгаарыг тогтоож өгдөг	Хариуцлагыг хамтаар хүлээх	Эрх, үүргийн аливаа хязгаарлалтгүй, нээлттэй
ICT хэрхэн ашигладаг	шийдвэр гаргахал хэрэглэдэг	Хэлэлцүүлэг явуулахал хэрэглэдэг	Мэдээлэл түгээх, мэдээлэл хүргэхэд хэрэглэдэг

Эх сурвалж: Astrom, J.2001. Should Democracy online be Quick, Strong or Thin ? *COMMUNICATION OF THE ACM*, p.51.

Харин судлаач Мартин Хилберт ардчиллын хөгжлийн 8 хувилбарыг авч үзсэн байдаг. /Хүснэгт 2/

/Хүснэгт 2/

Ардчиллын хувилбарууд	Шинж чанар	Давуу тал	Эрэлт
Полне ардчилал	<ul style="list-style-type: none"> - Шийдвэр гаргах эрх мэтгэл ард түмэнд байна - Улс төрийн илөгитут эрх мэтгэл багатай 	<ul style="list-style-type: none"> - Шууд оролцоо ба шүүн хэлэлцэх - Идэвхтэй оролцоо ба сэтгэл ханамж - Газарзүйн саядыг даван туулах - Ил үзэл бодолтнууд үүсэх. 	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн тогтворгүй байдал - Бүлгүүдийн хооронд шигтгэл сул
Кибер ардчилал	<ul style="list-style-type: none"> - Либериад байдал, бие даасан шийдвэр гаргахал төвлөрсөн 	<ul style="list-style-type: none"> - Төрийн болон хувийн үйл хэрэгт асуудлыг хамгийн доош түвшиндээ шийдвэрлэх зарчим 	<ul style="list-style-type: none"> - Олонхи нь ноёрдог - Цөөнх нь үл ойшоогдох
Плебситар ардчилал	<ul style="list-style-type: none"> - Лидерүүд нь хадгалшгүй байдлаар дархлагдсан байх 	<ul style="list-style-type: none"> - Сонгогчид, улс төрийн лидерүүдийн хооронд байнгын харилцаа, хариуцлага 	<ul style="list-style-type: none"> - Чөлөөт мандатаас "дархан эрх"-г мандагал шилжиж популизм үүсэх эрсдэлтэй
"Том ах"-ын ардчилал	<ul style="list-style-type: none"> - Төр нь ICT-г ашиглан хянаж, ажиглаж байдаг 	<ul style="list-style-type: none"> - Цахим засаглалын ашигдан терроризм болон гэмт хэрэгтэй тэмцэх 	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийн диктатур тогтоох сул талтай - Хувь хүний бодол олон нийтийн санал бодолд нөлөөлөх аюултай
Эдийн засгийн ардчилал	<ul style="list-style-type: none"> - Ард түмнээс илгэл хүлээгчсний хариуд төрийн легитим байдал үүсдэг 	<ul style="list-style-type: none"> - Сонгогчид сонгогдсон эрх мэдэлнүүдийн хооронд дахь мэдээллийн зөрүүтэй байдал багасна - Ард түмний оролцоо сэтгэл ханамж дээшилдэг 	<ul style="list-style-type: none"> - Улс төр нь санал авахад чиглэл нь үзүүдээр шинжтэй болно - Нийгмийн дотор жижиг бүлгүүд олноор үүсэх
Санал хураах ардчилал	<ul style="list-style-type: none"> - Бүхийн асуудлыг шууд санал хураахал, олон нийтийн санал асуулгаар шийдэх хандлага 	<ul style="list-style-type: none"> - Цахим технологийг өргөн ашиглах - Гэрээсээ ICT-ээр саналаа өгөх 	<ul style="list-style-type: none"> - Дижитал мэдээлэл бүтээгчрээ оролцох боломж гэгш бус - Саналын нууц байдал алдагдах эрсдэлтэй - Дээрх нөхцөлүүдээ шалтгаалан сэтгэл хөдлөлөөр санал илэрхийлэхэд хүргэх аюултай

“Ром”-ын ардчилал	- Ил тод байх зарчим - Өөрийн санаа бодолдоо төвлөрөх, санал илэрхийлэх	- Чөлөөт мэдээлэл, оролцоонд тулгуурлан бодлого хууль боловсруулах	- Иргэдийн хүлээлт эрх мэдэлтнүүдийн бодит байдал - Дээрх зөрүүнээ шалтгаалан “эдиг”-ийг хүсэмжлэх хандлагад автах
Хэлэлцүүлгийн ардчилал	- Олон нийтийн санаа бодол шийдвэр гаргалтын хоорон дахь гүүрний үүргийг ICT гүйцэтгэнэ	- Зөвшилцөл, санал зөрөлдөөнийг ил тод гаргаж ирдэг - Аль талыг барихгүй бие даасан нотолгоо үндэслэлийн үнэ цэнэ - Олон нийтийн санаа бодлыг чиглүүлэх	- Хэлэлцүүлгийн үр дүн нь туйлын үпэнэ тооцогдох эрсдэлтэй - Дээрхээс үүдэн ICT-ын үүргийг өргөмжлөх

Эх сурвалж: Hilbert, Martin .2007. *Digital Processes and Democratic Theory: Dynamics, risk and opportunities when democratic institutions meet digital information and communication technologies*, peer-reviewed online publication: <http://www.martinhilbert.net/democracy.htm>

Дээрхи загваруудад ICT хэрхэн хэрэглэж байгаагаас хамааран, шийдвэр гаргалт, хэлэлцүүлэг, мэдээлэл түгээлт нь өөр өөрөөр илэрч гарч ирдэг. Тухайлбал:

- ◆ Шийдвэр гаргалтын үед дараах 5 зүйлд анхаарал хандуулах шаардлагатай болдог. Үүнд:
 1. Цахим сонгуулийн системийг бүрдүүлсэн байх, өндөр түвшний нууцлалтай байх
 2. Цахим системийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байх
 3. Сонгуулийн зохион байгуулалт нь цахим системд зохицсон байх
 4. Сонгогчид цахим системээр саналаа өгөхөд бэлтгэгдсэн байх
 5. Цахим систем нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сонгуулийн тогтолцоонд зохицсон байх
 - ◆ Хэлэлцүүлэг явуулах үед дараах 3 зүйлийг анхаарах ёстой. Үүнд:
 1. Хэлэлцүүлэх асуудлаа үндэслэлтэй сонгож, зөв томъёолж тавих
 2. Хэлэлцүүлэг явуулахад ямар төрлийн мэдээллийн хэрэгслийг сонгож хэрэглэхээ сонгох (CMC FTF
 3. Хэлэлцүүлэг явуулах чадавхитай ур чадвар, компетени байх
 - ◆ Мэдээлэл түгээлтийн явцад анхаарч авч үзэх шаардлагатай 3 асуудал байна. Тухайлбал:
 1. Шийдвэр гаргах, сонголт хийхэд зориулсан мэдээлэл түгээлтийн орон зай, онцлог, зохион байгуулалт, үйл явц ямар байхыг тодорхойлох
 2. Мэдээллийн тухай хууль эрх зүйн орчин
 3. Мэдээлэл түгээгч нь түгээж байгаа мэдээллийнхээ танин мэдэхүйн ач холбогдол, сэтгэл зүйн асуудлыг анхаарч, тооцоолж үзсэн байх
- ICT-шийдвэр гаргалт, хэлэлцүүлэг, мэдээлэл түгээлт гэсэн дээрхи 3 тулгуур хүрээнд хэрэглэж байна. ICT Жинхэнэ ёсоор хэрэглэсний шалгуур нь иргэдийн ард түмний оролцоо болно. Энэ цахим ардчиллын хөгжлийг илэрхийлэх билээ.

НОМ ЗҮЙ

1. Astron. J.2001. Should Democracy online be Quick, Strong or Thin? *COMMUNICATION OF THE ACM*.
2. Barber, B. 1984. *Strong Democracy*. University of California Press, Berkely, CA.
3. Gronlund, A. 2001. *Democracy and IT- Framed Society*. *COMMUNICATION OF THE ACM*.
4. Hacker, K.L and van Dijk, K. (eds) 2000. *Dijital Democracy: Issues of Theory and Practice*. SALE, London.
5. 横江公美 『E-ポリテクス』、文春新書、2001年。
ЦАХИМ ХАЯГ
1. Hilbert, Martin .2007. *Digital Processes and Democratic Theory: Dynamics, risk and opportunities when democratic institutions meet digital information and communication technologies*, peer-reviewed online publication: <http://www.martinhilbert.net/democracy.htm>